



## ХАМТЫН АЖИЛЛАГАА

### Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх шинжээчдийн баг манай улсад ажиллалаа



Монгол Улсын авлигын эсрэг хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, үнэлгээ хийх зорилгоор Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын шинжээчдийн баг манай улсад ажиллав.

Шинжээчдийн багийн бүрэлдэхүүнд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын Авлигын эсрэг сүлжээний зөвлөх, багийн удирдагч Дмитро Котяр, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны Худалдан авах ажиллагааны бодлогын газрын ахлах зөвлөх Евгений Смирнов, Армени улсын Өндөр зэрэг дэвтэй албан тушаалтны ёс зүйн хорооны комиссар Лилит Петросян, Азербайжан улсын Авлигатай тэмцэх алба, Улсын ерөнхий прокурорын газрын прокурор Самир Махмудов, Литва улсын Авлигатай тэмцэх газрын Олон улсын харилцаа хариуцсан ажилтан Елена Кончевиците нар оржээ. Шинжээчдийн баг нь УИХ, Засгийн газар, төрийн болон төрийн бус байгууллага, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, бие даасан

шинжээчид, олон улсын байгууллага, гадаад улсын элчин сайдын яам зэрэг олон төлөөллийг оролцуулсан уулзалт зохион байгуулж, үнэлгээний асуултаудад хариулт авсан юм.

Монгол Улс нь Станбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2012 онд нэгдэн орсон бөгөөд 2014 онд тус байгууллагын Үнэлгээний баг манай улсын авлигын эсрэг үйл ажиллагаа, эрх зүйн орчинд анх удаа үнэлгээ хийсэн билээ. Үнэлгээний цар хүрээ нь авлигатай тэмцэх байгууллага, худалдан авах ажиллагаа, санхүүгийн дотоод хяналт шалгалт, дотоод аудит, шүүх, прокурорын байгууллага, хувийн хэвшил зэрэг байгууллагуудтай холбоотой үйл ажиллагаа, эрх зүйн орчноос гадна авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх асуудлуудыг хамарч байна.

**Шинжээчийн багийн ахлагч  
Дмитро Котярын ярилцлагыг  
II нүүрээс уншина уу.**

### Авлигатай тэмцэх газрын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааг Улсын Ерөнхий прокурорын газраас шалгав

Авлигатай тэмцэх газрын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд Улсын Ерөнхий прокурорын газраас шалгав. Уг шалгалт нь Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад хуулиуд, тэдгээрийг хэрэгжүүлэхээр гаргасан Улсын Ерөнхий прокурорын тушаал, албан даалгавар, заавар журмуудын хэрэгжилт, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийг хэрхэн хангаж байгаа байдлыг шалгаж дүгнэлт хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилготой юм байна.



Шалгалтын үеэр гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шалгаж шийдвэрлэх ажиллагаа, эрүүгийн хэрэг үүсгэх болон хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа, сэжигтнийг баривчлах болон цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ, мөрдөн байцаалтын ажиллагааг нь түдгэлзүүлсэн болон хэрэгсэхгүй болгосон хэргүүд, эд мөрийн баримт, барьцаа, хохирол төлүүлэхээр авсан мөнгө, валют, үнэт цаас, үнэт, эдлэл, битүүмжилсэн эд хөрөнгийг хүлээн авах, хадгалах, шийдвэрлэх арга хэмжээ, шүүхэд шилжүүлсэн хэргийн шийдвэрлэлтийн байдалтай тус тус танилцав.

БАЙР СУУРЬ

## Дмитро Котяр: Авлигатай тэмцэх бие даасан институцээ татан буулгавал Монголын хувьд маш том ухралт болно

*Авлигатай тэмцэх чиглэлээр Монгол Улсад өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж дүгнэхээр ирсэн шинжээчдийн багийн ахлагч, Авлигын эсрэг сүлжээний зөвлөх Дмитро Котяртай ярилцсан юм.*

**-Зөвлөмжийн хэрэгжилт ямаршуухан байгааг дүгнэхэд хугацаа шаардах байх. Гэхдээ долоо хоногийн хугацаанд энд ажиллахдаа авсан мэдээллүүд дээр үндэслээд ерөнхийд нь хэлэхэд Монгол Улс өнгөрсөн нэг жилд хэр их ахиц гаргаж вэ?**

-Олон өөр салбар, сэдвээр хоорондоо эрс ялгаатай, нарийвчилсан зөвлөмж өгсөн болохоор бүгдийнх нь хэрэгжилтийг ерөнхийд нь дүгнэж хэлэх боломжгүй л дээ. Гэхдээ Авлигын эсрэг хууль эрхзүйн орчны шинэчлэлээр Монгол Улс багагүй дэвшил гаргасан байна. Эрүүгийн хуулийн авлигын эсрэг заалтын хамрах хүрээг илүү тодорхой болгож, олон улсын жишигт нийцүүлэхээр ажиллаж байгаа нь сайшаалтай. Мөн энд зориуд дурдахад улс төрийн намуудын санхүүжилтийг хуульчлахаар яригдаж байгаа нь маш чухал. Хамгийн гол нь улс төрийн санхүүжилтийг нээлттэй, ил тод байлгах тогтолцоог бий болгохын тулд иж бүрэн шинэчлэл хийх хэрэгтэй. Цаашид хийх зүйл маш их байна. Гэхдээ одоогийн бодлого үйл ажиллагаанаас харахад Монгол Улс авлигатай тэмцэх бодлого, үйл ажиллагааны хувьд зөв чиглэлд явж байгаа, явахыг хичээж байгаа гэж хэлмээр байна.

**-Манай улс одоогоос найман жилийн өмнө авлигатай тэмцэх бие даасан, хараат бус институцтэй болсон. Таны бодлоор түүнээс хойш өнгөрсөн хугацаанд авлигын эсрэг хэр үр дүнтэй тэмцсэн гэж харж байгаа вэ. Ер нь үр дүн гараагүй, авлигатай тэмцэх ийм тусгай институц байх шаардлагагүй гэж үздэг хэсэг бас бий. Олон улсын жишиг нь ямар байдаг юм бэ?**

-Дэлхийн олон улс орон авлигатай тэмцэх бие даасан институцтэй. Гэхдээ үйл ажиллагааны цар хүрээ, тусгайлсан чиг үүргээсээ хамаараад загварын хувьд ялгаатай л даа. Зарим нэг улс нь авлигаас сэргийлэх, нөгөө нь авлигын гэмт хэргийг мөрдөх, илрүүлэх чиг үүрэгтэй хэд хэдэн агентлагтай байхад өөр хэсэг нь Монгол шиг нэг институцтэй байдаг. Монгол дахь институцийг сайн загвар гэж үздэг. Тиймээс ч дэвшил гаргаж чадаж байгаа. Харин байх шаардлагагүй гээд татан буулгах юм бол Монголын авлигын эсрэг тэмцэлд гарцаагүй маш том ухралт болно. Тиймээс бидний зүгээс энэ институцийг үгүй болгох биш улам хүчирхэгжүүлэхийг тууштай дэмжиж байгаа. Боловсон хүчний хувьд ч чадваржуулж, салбар бүрээр нь тусгайлан мэргэшүүлэх, сургах, орон тоог нь нэмэгдүүлж, боломжтой бол орон нутагт салбаруудтай болгох хэрэгтэй. Нөгөөтэйгүүр, прокурор, эрүүгийн хэргийн шүүх зэрэг хууль хэрэгжүүлэгч бусад



байгууллагыг ч зөвхөн авлигын гэмт хэргийн чиглэлээр нарийн мэргэшсэн боловсон хүчнээр хангах тал дээр анхаарч, өөрчлөлт шинэчлэл хийх хэрэгтэй. Шүүх засаглалд мөн шинэчлэл шаардлагатай байна. Учир нь, өнөөдөр Монголын шүүх засаглал хангалттай хараат бус байж чадахгүй байна. Шүүгчдийн сонгон шалгаруулалт, Шүүхийн ерөнхий зөвлөлийн удирдлагын томилгоо зэрэгт Засгийн газар, УИХ зэрэг улс төрийн байгууллагуудын оролцоо хэтэрхий их байна. Эдгээр үйл явцыг улс төрийн оролцооноос бүрэн ангижруулах нь туйлын чухал. Энэ мэтчилэн өөрчлөлтүүдийг хийчих юм бол Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаа илүү үр дүнтэй болно.

**-Нэг ийм маргаан яваад байдаг юм. Цагдаа, прокурор, шүүгч нар гээд хууль хяналтын байгууллагуудын холбогдсон авлигын хэргийг Авлигатай тэмцэх газар шалгах нь буруу гэж. Энэ талаар та юу хэлэх вэ. Олон улсын зөв туршлага, жишиг нь ямар байдаг юм бол?**

-Авлигатай тэмцэх газар, энэ бие даасан институц үнэхээр л бие даасан, хараат бус юм бол улстөрч, шүүгч, прокурор гээд бүх салбар, төвшний албан тушаалтны холбогдсон авлигын хэргийг шалгахад асуудалгүй. Юун төлөө авлигатай тэмцэх тусгай үүрэгтэй институц байгуулсан билээ. Тэр бүү хэл энэ институц зүгээр нэг эмнэлэг, сургуулийн ажилтантай холбоотой энгийн, доогуур төвшний хэргийг цагдаагийн байгууллагад ч юм уу даатгаад, улстөрчид, шүүх, прокурорынхонтой холбоотой илүү өндөр төвшний авлигын хэрэгт анхаарлаа хандуулах нь зүйтэй.

**-“Транспэрэнси Интернэшнл”-ээс гаргадаг индексээр манай улсад авлигын төвшин аажмаар ч гэсэн буурч байгаа гэж дүгнэж болохоор байгаа. Харин бодит байдал дээр өөрчлөлт ямар байгаа талаар хөндлөнгийн шинжээчийн хувьд юу гэж дүгнэж байна вэ?**

-Энэ тал дээр бол дотор нь амьдарч буй та бүхэн л илүү бодитой дүгнэлт өгөх болов уу. Ерөнхийдөө индексээс харсан ч өөрийн авсан мэдээлэл дээр үндэслэн хөндлөнгийн шинжээчийн нүдээр харахад ч зөрөг өөрчлөлт, ололтууд гарч байгаа. Гэхдээ л хангалттай биш. Авлига, хээл хахууль Монголын хувьд санаа зовоосон, ноцтой асуудлуудын нэг хэвээрээ

байна. Энд ирээд нэг зүйлийг анзаарч байхад хэдийгээр авлига ноцтой асуудал хэвээрээ байгаа ч яг өнөөдрийн байдлаар эдийн засгийн хүндрэлтэй холбоотойгоор олон нийт авлигын асуудалд анхаарал хандуулахгүй, чухалчилж үзэхгүй байх шиг байна. Авлигыг яаж бууруулах вэ гэдгээс илүү өнөөдрийн идэх хоол яаж олох билээ гэдэгт илүү санаа зовж байх шиг санагдсан. Уг нь авлигатай тэмцэнэ гэдэг зөвхөн энэ институцийн хийх ажил биш л дээ. Шүүх, прокурор, хэвлэл мэдээллийн байгууллагууд, олон нийт бүгд оролцож байж шийдэгдэх асуудал. Биеэ даасан институцээс гадна хараат бус шүүх, прокурорын байгууллага, мэргэжлийн, улс төрөөс хараат бус төрийн алба, мэдээллийн хүртээмжтэй ил тод байдал, хэвлэлийн эрх чөлөө, улс төрийн санхүүжилтийн зөв тогтолцоог гээд олон хүчин зүйлээс шалтгаална. Бүгд хоорондоо уялдаа холбоотой.

**-Дэлхийн улс орнуудаас сүүлийн үед авлигыг богино хугацаанд хамгийн амжилттай бууруулж чадаж байгаа орнуудын жишээг хэлж болох уу?**

-Зөвлөлт Холбоот Улсын задралаас хойш Эстони, Литви, Латви улс авлигатай хийсэн тэмцэлд хамгийн их дэвшил гаргасан гэдгийг дэлхий нийтээрээ л мэддэг. Польш, Румыныг мөн дурдаж болно. Тэдгээр улсын хувьд бие даасан, маш хүчирхэг институцийг бий болгож, хууль эрхзүйн орчноо өөрчлөн шинэчилж чадсан. Бие даасан институцтэй болсноороо авлигыг бууруулах тал дээр амжилт олж байгаа өөр нэг орон бол Словени. Азид Хонконг, Сингапур бол сонгодог жишээ.

**-Амжилт олсон барууны орнуудтай харьцуулахад ийм богино хугацаанд амжилттай шинэчлэл өөрчлөлт хийхийн тулд бид бодлогын хэрэгжилт дээр хатуу хандах хэрэгтэй байх.**

-Үнэхээр шинэчлэл хийх л гэж байгаа бол хатуу хандах нь мэдээж зүйтэй. Авлига гэдэг бол гэмт хэрэг. Гэмт хэрэг хийсэн л бол зохих шийтгэлийг хүлээлгэж байж шударга ёс тогтоно. Хамгийн гол нь албан тушаал, намын харьяалал, танил талаар ялгаварлах асуудал байж болохгүй. Хууль бүх хүнд тэгш үйлчлэх ёстой. Хатуу, гэхдээ шударга, эрх тэгш. Гэхдээ хатуу байна гээд хүний эрхийг зөрчих асуудал байж болохгүй. Тодорхой хэмжээний залхаан цээрлүүлэлтгүйгээр аливаа гэмт хэрэгтний авлига, хээл хахууль авахыг зогсоох боломжгүй. Гэхдээ нөгөөтэйгүүр сэргийлэх бодлого, арга хэмжээ чухал. Жишээ нь, улс төрийн албан тушаалтнууд өндөр цалинтай байх нь зүйтэй. Төрийн албан хаагчид өндөр нэр хүндтэй, хангалттай хэмжээний цалинтай байх нь зүйтэй. Дээр нь, тэр албан тушаалд хүрэхэд илүү өндөр шаардлагатай, өрсөлдөөнтэй, өрсөлдөөн нь шударга байх хэрэгтэй.

**Б.Нарантуяа**  
“Үндэсний шуудан” сонин

## МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

### Алслагдсан дүүрэг, хорооны иргэдтэй уулзав

Авлигатай тэмцэх газраас олон нийттэй харилцах чиглэлээр нийслэлийн зарим алслагдсан дүүрэг, хорооны болон хотын ойролцоох сумдын иргэдтэй хийх уулзалтыг зохион байгууллаа. Иргэдэд авлигатай тэмцэх байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг, бүрэн эрхийг танилцуулах, авлига ашиг сонирхлын зөрчлийн эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, авлигын нийгмийн хор аюулыг таниулах, сүүлийн үед хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар мэдээлэх зорилгоор энэхүү цуврал уулзалтыг зохион байгуулж байна. Одоогийн байдлаар уулзалтад нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг, Налайх дүүргийн 5 дугаар хороо, Баянзүрх дүүргийн 11, 20 дугаар хороо, Төв аймгийн Батсүмбэр, Эрдэнэ сумын иргэдийг хамруулаад байна.



Уулзалтын үеэр иргэд Авлигатай тэмцэх газарт их итгэл хүлээлгэж байгаагаа илэрхийлж, “нийгмийн болохгүй, бүтэхгүй бүхнийг баллуурдаж, энэ улс орны ноён нуруу нь байх ёстой” гэж саналаа хэлж байв. Авлигатай тэмцэх газар иргэд, олон нийттэй хийх уулзалтыг цаашид уламжлал болгон зохион байгуулахаар төлөвлөж байна.

### УИХ-ын дэргэдэх байгууллагуудын дунд зохион байгуулсан спортын тэмцээнд 3 алт, нэг хүрэл медаль хүртэв

Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсан 25 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан спортын наадам сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээнээр өндөрлөж, дүнгээ гаргалаа. Авлигатай тэмцэх газрын сагсан бөмбөгийн эрэгтэй баг тамирчид, гар бөмбөгөөр байгууллагын баг тамирчид, мөн шатрын эрэгтэй ганцаарчилсан төрөлд тус тус түрүүлж, алтан медаль хүртэв. Түүнчлэн шатрын тэмцээнд багаараа 3 дугаар байр эзэлж, хүрэл медаль хүртлээ. УИХ-ын дэргэдэх байгууллагуудын 7 төрөлт бүхий спорт наадмыг Авлигатай тэмцэх газар 2010 онд анх санаачлан зохион байгуулж байсан бөгөөд өдгөө уламжлал болж хэвшээд байна.

### “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-т нэгдэв

Авлигатай тэмцэх газрын ажилтан, албан хаагчид 2015 оны 5 дугаар сарын 2-ны өдөр нийслэлийн Сүхбаатар дүүргийн Сөүлийн гудамжин дахь байгууллагынхаа ногоон байгууламжид мод тариллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигаар жил бүрийн 5 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гарагийг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” болгон зарласантай холбогдуулан Авлигатай тэмцэх газрын албан хаагчид өөрсдийн мөнгөн хуримтлалаар нийт 450 ширхэг тарваган хайлаас, 5 багц нохойн хошууны мод, ногоон гацуурыг худалдан авч мэргэжлийн инженерийн зөвлөмжийн дагуу суулгаж тарив. Түүнээс гадна 72 метрийн урттай ургамлан хашлага байгуулж, албан газрынхаа орчмын ногоон байгууламжийн хогийг цэвэрлэн тохижилтын ажлыг хийсэн байна.

Авлигатай тэмцэх газрын ажилтнууд өнгөрсөн жилийн “Бүх нийтээр мод тарих өдөр”-өөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд мод тарьсан билээ.

### “Тохижилт сайтай цэмцгэр байгууллага”-аар нэрлэв

Авлигатай тэмцэх газрыг “Тохижилт сайтай цэмцгэр байгууллага”-аар нэрлэж, “Баярлалаа” хэмээх тусгай тэмдэг байрлуулах эрхтэйг нийслэлийн Сүхбаатар дүүргийн 5 дугаар хорооны Засаг даргын ажлын албанаас мэдэгдэв.

Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан нийслэлийн 2015 оны шилдэг тохижилт, ногоон байгууламжтай, цэмцгэр байгууллага, аж ахуйн нэгж шалгаруулах болзолт уралдаанд Авлигатай тэмцэх газар дүүргийн нутаг дэвсгэртээ манлайлан оролцож байгааг ийнхүү сайшаалаа. Уг уралдаанд нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бүх байгууллага, аж ахуйн нэгж, иргэн өмчийн төрөл хэлбэр харгалзахгүйгээр хамрагдаж байгаа юм байна.

Уралдаан нь нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бүх байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, нийгмийн хариуцлагыг өндөрсгөх, тохижилт бүтээн байгуулалт, хог хаягдал, цэвэрлэгээний менежментийг сайжруулах, ажлын шинэ санал санаачилгыг дэмжих, хотын өнгө үзэмжийг дээшлүүлэх замаар иргэдийн ая тухтай орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлж байгаагаараа ач холбогдолтой юм.

Улаанбаатар хотын тохижилтод идэвх чармайлттай оролцож, онцгой ахиц дэвшил гаргасан байгууллагад сайшаасан “Тусгай тэмдэг”-ийг Авлигатай тэмцэх газарт байрлууллаа.

## ТОВЧХОН \* ТОВЧХОН

Авлигатай тэмцэх газарт 2015 оны 06 дугаар сарын 15-ны байдлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгуулахаар хандсан нийт 199 өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авснаас 164 өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгаж шийдвэрлэв. \*\*\*

Эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, тухайн гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгах чиглэлээр нийслэлийн Баянгол дүүргийн Татварын хэлтсийн дарга Р.Мөнх-Эрдэнэд Мөрдөн байцаагчийн мэдэгдэл хүргүүлэв. \*\*\*

Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн хариуцлага тооцох тухай албан бичгийн дагуу Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ тушаал гаргаж, Хүүхдийн төлөө үндэсний газрын дарга И.Нарантуяад албан тушаалын цалинг 2 сарын хугацаанд 30 хувиар бууруулах сахилгын шийтгэлийг ногдуулж, цаашид авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаагаа сайжруулахыг үүрэг болгожээ. \*\*\*

2015 оны эхний 5 сард хуульд заасан харьяаллын 217 үйлдэл, 204 холбогдогчтой эрүүгийн 147 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна. Мөрдөн шалгасан эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийг авч үзвэл 23 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорт шилжүүлэв. \*\*\*

Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудад холбогдуулан Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлийн 263.2, 150 дугаар зүйлийн 150.3-д зааснаар мөрдөн байцаалтын ажиллагаа явуулав. \*\*\*

Монгол Улсын авлигын эсрэг хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, үнэлгээ хийх зорилгоор хүрэлцэн ирсэн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын шинжээчдийн баг манай улсад ажиллав. \*\*\*

Нэр бүхий албан тушаалтны хууль зөрчсөн үйлдлийг дахин гаргуулахгүй байхад анхаарч ажиллах талаар нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг дарга Д.Бадарсанд албан бичиг хүргүүлэв. \*\*\*

Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг иргэний гомдол, мэдээллийн мөрөөр болон төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд хянан шалгадаг бөгөөд 2015 он гарсаар Нийгмийн даатгалын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Монгол банк болон Увс, Говь-Алтай аймгийн холбогдох албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгалаа.

## ОРОН НУТАГТ

### **Булган аймгийн нэр бүхий албан тушаалтнуудад зөрчил арилгуулах албан бичиг хүргүүлэв**

Авлигатай тэмцэх газраас Булган аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга О.Наранжаргал, Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Г.Эрдэнэ нарт зөрчил арилгуулах чиглэлээр албан бичиг хүргүүлэв.

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг Булган аймгийн хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах явцад Төрийн албаны хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8 дахь заалтыг зөрчиж Булган аймгийн Баян-Агт сумын ИТХ-ын төлөөлөгч Г.Соёлмааг тус сумын Засаг даргын Тамгын газрын төсвийн мэргэжилтнээр, Булган аймгийн Сайхан сумын ИТХ-ын төлөөлөгч Б.Энхтөрийг тус сумын Нийгмийн даатгалын байцаагчаар тус тус томилсныг тогтоов.

Энэ нь Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтыг мөн зөрчсөн байх тул Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээ авч, дүнг эргэн танилцуулахыг дээрх нэр бүхий албан тушаалтнуудад үүрэг болгов.

### **Тендерт шалгарсан аж ахуйн нэгжээс мөнгө авсан асуудлыг хянан шалгав**

Авлигатай тэмцэх газарт иргэнээс ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авч Авлигын эсрэг хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.4.6 дахь заалт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн хянан шалгалаа.

Хяналт шалгалтаар Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын удирдах албан тушаалтан болох Н нь тус аймагт зохион байгуулсан тендер сонгон шалгаруулах Үнэлгээний хороонд гишүүнээр томилогдож ажилласан бөгөөд тендерт шалгарч ажил үүрэг

гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад хяналт тавих явцдаа нэр бүхий компаниудаас зээл нэрийн дор нийт 6.000.000 төгрөг, эмчилгээний зардалд тусламж болгон 200.000 төгрөг авсан нь тогтоогдов.

Хяналт тавьж ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагаас дээрх санхүүгийн эх үүсвэрийг бий болгосон нь Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7-д “албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх” гэж заасныг, мөн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан төлбөр авахтай холбогдсон хязгаарлалтыг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.3-т “хувийн ашиг сонирхлын үүднээс хууль бус санал тавих, хүлээж авах зэрэг зөрчил, хууль бус үйлдэл гаргахгүй байх” гэж заасныг тус тус зөрчсөн тул холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар Говьсүмбэр аймгийн Засаг дарга Л.Одсэрд Авлигатай тэмцэх газраас албан бичиг хүргүүлээд байна.

### **Авлигатай тэмцэх газраас өгсөн зөвлөмжийг Ховд аймгийн Дарви сумын Засаг даргын Тамгын газар биелүүлж ажиллажээ**

Авлигатай тэмцэх газраас өгсөн Зөвлөмжийн дагуу Ховд аймгийн Дарви сумын Засаг даргын Тамгын газар тодорхой арга хэмжээ зохион байгуулжээ.

Тус газраас томилогдсон ажлын хэсэг 2014 онд Ховд аймгийн сумдад авлига, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй газар дээр нь танилцсан бөгөөд энэ жил тус аймгийн Дарви, Зэрэг, Манхан суманд дахин ажиллаж, өнгөрсөн жил гарсан алдаа дутагдал, зөрчлийг арилгах чиглэлээр авсан арга хэмжээтэй танилцав.

Дарви сумын Засаг даргын захирамжаар 5 хүнийг нийтийн албанд томилохдоо урьдчилсан мэдүүлгийг нь Авлигатай тэмцэх газраар хянуулаагүй байсан зөрчлийг арилгасан байна. Түүнчлэн 2013 онд Засаг даргын

захирамжаар байгуулсан 1, Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар байгуулсан 2 үнэлгээний хорооны нийт 13 гишүүний 9 нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан мэдэгдлийг гаргаагүй зөрчил илэрч байсан бол 2014 оны сүүлийн хагас жилээс үнэлгээний хорооны бүх гишүүд уг мэдэгдлийг гаргах болжээ. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 2013 онд хог цэвэрлэгээний техник худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байх бөгөөд “Гүнцэнгэг” ХХК шалгарч, нийт 44 сая төгрөгийн өртөгтэй өөрөө буулгагч автомашин, авто ачигч нийлүүлэхээр гэрээ хийж, дээрх техникийг нийлүүлсэн байх ба эдгээр техник хэрэгслийн өмчлөгч нь иргэний нэр дээр байсныг Засаг даргын Тамгын газрын өмчлөлд бүртгэж авсан байна.

### **Дүүргийн тэргүүлэгчдэд нэмэгдэл урамшуулал олгодог шийдвэрийг хүчингүй болгууллаа**

Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн албан бичгийн дагуу нийслэлийн Налайх дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар тогтоол гаргаж, холбогдох хууль тогтоомж зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгов.

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг нийслэлийн Налайх дүүрэгт авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцдаа тус дүүргийн ИТХ-аас батлан гаргасан дүрэм журмуудыг хянан үзсэн юм. Тус дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд нэмэгдэл урамшуулал олгодог нь хууль тогтоомжоор олгогдоогүй эрхийг хэрэгжүүлсэн гэж Авлигатай тэмцэх газар үзэж, дээрх урамшуулал олгохтой холбоотой шийдвэрийг хүчингүй болгуулахаар албан бичиг хүргүүлсэн.

Налайх дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд сар бүр 15 мянган төгрөгийн нэмэгдэл урамшуулах олгохыг зөвшөөрсөн 2007 оны тогтоолыг хүчингүй болгосон талаар Авлигатай тэмцэх газарт хариу мэдэгдлээ.

## МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

### Булган аймгийн ИТХ-ын 10 төлөөлөгч 1-10 сая төгрөгийн банкны хадгаламжийн хүүг мэдүүлээгүй байна

Авлигатай тэмцэх газраас авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, албан тушаалтны мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны болон 2015 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа, 2013, 2014 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цаасаар буюу цахимаар мэдүүлсэн, "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай" мэдэгдэл, тайлбарыг гаргасан, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулсан, тэдгээрийн шийдвэрлэлтийн байдлыг хянан шалгах ажиллагааг Булган аймагт үргэлжлүүлэв.

Аймгийн ИТХ-ын 10 төлөөлөгч 1-10 сая төгрөгийн банкны хадгаламжийн хүүг орлого хэсэгт мэдүүлээгүй, мөн хөрөнгө, орлого, зээл, хуулийн этгээдийг мэдүүлээгүй байна. Түүнчлэн хувийн орон сууц, газар болон орон сууц, автомашин, бусад хөрөнгөө худалдан борлуулсан талаар мэдүүлээгүй нийт 22 албан тушаалтан байна.

Авлигатай тэмцэх газраас авлига, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг хууль тогтоомжид заасныг анхаарч ажиллах, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулж, авсан арга хэмжээний талаар хариу мэдэгдэхийг хүссэн албан бичгийг Булган аймгийн ИТХ-ын дарга Д.Батсайхан, Засаг дарга Д.Эрдэнэбат нарт хүргүүлжээ.

### Увс аймгийн 364 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийг хянан шалгав

Увс аймгийн болон тус аймгийн Улаангом, бусад сумын ИТХ, Засаг даргын Тамгын газар, харьяа агентлаг, 19 сумыг хамруулан нийт 364 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгахад хамаарал бүхий этгээд болон нэгдмэл сонирхолтой этгээдийн талаар, мөн хөрөнгө, зээл, хадгаламж, дансны үлдэгдлийг мэдүүлээгүй, эх үүсвэрийг тодорхой тайлбарлаагүй, албан тушаалд томилогдсон ч 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ гаргаагүй, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ гаргалгүйгээр нийтийн албанд томилогдсон зэрэг нийтлэг зөрчил илэрлээ. Түүнчлэн аймгийн болон сумдын ИТХ-ын нийт 58 төлөөлөгч 1-70 сая буюу түүнээс дээш төгрөгийн банкны хадгаламжийн хүүг мэдүүлээгүй байна.

Авлигатай тэмцэх газраас Авлигын эсрэг

хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасныг анхаарч ажиллах, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулж, авсан арга хэмжээний талаар хариу мэдэгдэхийг хүссэн албан бичгийг Увс аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга Ч.Чимэд, Засаг дарга Д.Цэндсүрэн нарт хүргүүлжээ.

### Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал Д.Нямхүүд хариуцлага тооцуулах албан бичиг хүргүүлэв

Авлигатай тэмцэх газраас болон бусад байгууллагын гаргасан судалгааны дүнгийн мөрөөр 2015 оны авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, арга зүйн удирдлагаар хангах, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, хууль тогтоомжийн хэрэгжилттэй газар дээр нь танилцах зорилгоор Халдварт өвчин судлалын үндэсний төвд ажиллав.

Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах явцад хэд хэдэн зөрчил, дутагдал тогтоогдлоо. Тухайлбал, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал Д.Нямхүү нь өөртөө удаа дараа нийт 5 сая 500 гаруй мянган төгрөгийн урамшуулал, мөн нийт 3 сая 100 гаруй мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна. Түүнчлэн Сүрьеэгийн клиникийн 10 сая 800 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий засварын ажлыг үнийн харьцуулалт хийлгүйгээр "Дойт трейд" ХХК-тай шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байв.

Авлигатай тэмцэх газраас Эрүүл мэнд, спортын сайд Г.Шийлэгдамбад хүргүүлсэн албан бичигтээ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.4-т заасны дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал Д.Нямхүүд хариуцлага хүлээлгэж, цаашид дээрх зөрчил, дутагдлыг дахин гаргуулахгүй байх чиглэлээр нийт эрүүл мэндийн байгууллагын албан тушаалтнуудад урьдчилан сэргийлэх зорилгоор танилцуулахыг хүслээ.

### Эцэг, эхээс хандив цуглуулж байгаа гомдлын мөрөөр шалгалтын ажиллагаа явуулав

Авлигатай тэмцэх газрын 1800-1969 утсаар ирүүлсэн "Сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд нь эцэг эх, асран хамгаалагч

нараас хууль бусаар хандив цуглуулж байна" гэх гомдол, мэдээллийн дагуу холбогдох шалгалтын ажиллагаа явуулахад Эрүүгийн хуульд заасан албан тушаалын гэмт хэрийн бүрэлдэхүүний шинжийг хангахгүй боловч холбогдох хууль тогтоомж зөрчсөн байна.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 156 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Ц.Сарантуяа нь Нийслэлийн Боловсролын газрын 2013-2014 оны хичээлийн жилд гаргасан журмын дагуу 2 настай хүүхдүүдийг 2014 онл бүртгэж авахдаа хүүхдүүдийн эцэг, эхэд цэцэрлэгийн нөхцөл байдал, архивын өрөө болон бусад засвар үйлчилгээний шаардлагыг танилцуулж, 100 мянган төгрөгийн хандив, тусламж үзүүлэх хүсэлтээ гаргаж, хандиваа өөрөө биечлэн зохион байгуулсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хандив авахтай холбогдох хязгаарлалтыг зөрчсөн нь тогтоогдлоо.

Нийслэлийн Баянгол дүүргийн 76 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Г.Оюунсүрэнд холбогдуулан гаргасан гомдол, мэдээллийн дагуу шалгалт явуулахад Боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасныг тус тус зөрчсөн байна. Тэрээр төрсөн охин С-ийг ажилд томилсон тушаал гаргасан боловч түүнийг 2014 оны 10, 11, 12 дугаар сард ажиллаагүй байхад нягтлан бодогч Ц нь нийт олговол зохих 1 620 959 төгрөгийг улсын төсвөөс гаргажээ. Түүнчлэн 2014 онд ажил хөдөлмөрөөрөө хошуучлан ажилласан нэр бүхий 5 хүнд шагналт цалин олгосон боловч өөрсөдтэй нь тохирч 960 мянган төгрөгийг буцаан авч, цэцэрлэгийн тохижилтын ажилд зарцуулсан нь хандивыг санд төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг төрийн сангийн дансанд байршуулах бөгөөд тусгай дэд данс нээх, сургууль цэцэрлэгийн аж ахуй болон жижиг мөнгөн санг хариуцдаг нярав давхар хариуцан ажиллахыг хориглох, нийтийг хамарсан албадлагын болон тэгшитгэн хураасан шинжгүй байх, хандивласан хөрөнгийг зориулалтын арга хэмжээнд зарцуулахаар тус тус журамласныг баримтлаагүй байна.

Авлигатай тэмцэх газраас дээрх албан тушаалтнуудад Төсвийн тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, холбогдох дүрэм журмыг зөрчсөн үйлдэлд нь хариуцлага тооцож, дахин ийм асуудал гаргуулахгүй байхад анхаарч ажиллах талаар Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Ш.Булга-Эрдэнэд албан бичиг хүргүүлжээ.

## ДЭЛХИЙ ДАХИНД

### Хүү нь авлигын хэрэгт холбогдсон Нью-Йорк мужийн сенатор албан тушаалаа өгөв

**АНУ.** Хүү нь авлигын хэрэгт холбогдсоноос долоо хоногийн дараа Нью-Йорк мужийн Сенатын Олонхийн бүлгийн тэргүүн Деан Скэлос албан хяналтын байгууллагууд 67 настай сенатор Скэлос болон түүний хүү 32 настай Адам нарыг бусдаас хээл хахууль авахаар шахсан, сүрдүүлсэн хэрэгт буруутгасан юм.

Прокуроруудын мэдэгдэж байгаагаар



сенатор Скэлос хууль тогтоомж болон дэд бүтэцтэй холбоотой асуудлаар дэмжлэг үзүүлсний төлөө хүүд нь 200 гаруй мянган ам.доллар өгөхийг үл хөдлөх хөрөнгийн болон байгаль орчны технологийн компаниудаас шаардаж сүрдүүлсэн байна. Өөрийгөө буруугүй хэмээн мэдэгдэж байгаа Скэлосын энэ хэрэгт нь тус мужийн Сенатын танхимын гишүүдээс авлигын хэрэгт холбогдож байгаа 5 дахь тохиолдол нь болж байна.

### Авлигатай тэмцэх хөтөлбөр 3.7 их наяд донг хэмнэх боломж олгосон

**Ханой.** 2011-2015 онд хэрэгжиж буй Авлигатай тэмцэх хөтөлбөр 3.7 их наяд донг хэмнэх боломж олгосон хэмээн уг хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх хурал дээр мэдэгдсэн байна.

Өнгөрсөн хугацаанд авлигын шинж тэмдэг бүхий намын 1000 гаруй гишүүн, намын 278 байгууллагыг шалгаснаас 163 байгууллагад нь зөрчил илэрсэн хэмээн Авлигатай тэмцэх байнгын хорооны илтгэлд дурджээ. Түүнчлэн 5775 өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэсэн байна. Авлигатай тэмцэх чиглэлээр цаашид дорвитой арга хэмжээ авч тодорхой стратеги боловсруулах явдал чухал

хэмээн Намын төв хорооны Дотоод хэргийн хорооны дэд дарга Пам Ан Туан хурлын үеэр тэмдэглэсэн байна.

### Хил дээрх авлигатай тэмцэхийн тулд Малайз, Тайланд улсууд хамтарсан ажлын хэсэг байгууллаа

**Малайз.** Малайз-Тайландын хил дээрх авлигатай тэмцэхийн тулд Малайзын Авлигатай тэмцэх хороо, Тайландын Үндэсний авлигатай тэмцэх хороо хамтран ажлын хэсэг байгуулаад байна.

“Өнгөрөгч сард зохион байгуулагдсан Зүүн өмнөд Азийн Авлигатай тэмцэх талуудын нарийн бичгийн дарга нарын уулзалтын үеэр хоёр талын уулзалт зохион байгуулсны үр дүнд энэ ажлын хэсгийг байгууллаа. НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 48, 49 дүгээр зүйлд зааснаар авлигатай тэмцэх чиглэлийн хууль сахиулах хамтарсан үйл ажиллагаа явуулах эсэхийг ажлын хэсэг шийдвэрлэх болно” хэмээн Малайзын Авлигатай тэмцэх хорооны Бодлого, төлөвлөлт, судалгааны хэлтсийн дарга Датук Ахмад хэлэв. Тус ажлын хэсгийн бусад чиг үүрэгт хоёр талын авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагууд болох Малайзын Авлигатай тэмцэх хороо, Тайландын Үндэсний авлигатай тэмцэх хорооны хамтын ажиллагааг өргөжүүлэх, Малайз-Тайландын хил дээрх хууль сахиулах чиг үүрэг бүхий бусад байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх зэрэг орж байгаа аж.

### Хувийн нарийн бичгийн дарга нь авлигын хэрэгт холбогдсоны улмаас дэд ерөнхийлөгч огцрохыг хүсэв

**Гватемал.** Хувийн нарийн бичгийн дарга нь гаалийн авлигын хэрэгт холбогдсоны улмаас Гватемал Улсын дэд ерөнхийлөгч албан тушаалаасаа огцрох хүсэлт гаргасан ба Конгрессоос хүсэлтийг нь дэмжиж албан ёсоор огцров.

Дэд ерөнхийлөгч Роксана Балдетт хийсэн мэдэгдэлдээ, халдашгүй дархан байдал нь мөрдөн байцаалтын ажиллагаанд нөлөөлөх боломжтой учир албан тушаалаасаа огцрох шийдвэр гаргаж байгаа бөгөөд уг хэрэгт холбогдох мөрдөн байцаалтын ажиллагаанд

хамтарч ажиллахаа амлажээ. Огцорсны дараагаар шүүхээс мөрдөн байцаалтын хугацаанд Балдеттийг хилээр гадагш гаргахгүй байх шийдвэр гаргасан юм. Балдетт бол Гватемал Улсаас авлигын хэргийн улмаас огцорч байгаа анхны дэд ерөнхийлөгч бөгөөд прокурор түүнийг энэ хэрэгт шууд холбоотой гэж одоогоор үзэхгүй байгаа юм.

Балдеттийн туслах асан Хуан Карлос Монзон Рожак гаалийн хяналтыг сулруулахын тулд хээл хахууль авч, улсад олон сая долларын хохирол учруулсан гэж буруутгаж байгаа билээ. Хамгийн сүүлд Монзоныг хилийн чанадад байгааг тогтоосон бөгөөд түүнийг холбогдох байгууллагууд эрэн сурвалжилж байгаа юм. Энэхүү авлигын хэргийн сүлжээнд хувийн хэвшил, татварын байгууллагын удирдлага болон төрийн албан хаагч зэрэг 50 хүн холбогдоод байгаа бөгөөд тэдний 27-г нь прокуророос баривчлаад байгаа аж. Мөн хэрэгт холбогдсон 3 сэжигтнийг суллуулахын тулд нэгэн шүүгчид хээл хахууль өгсөн хэргээр 5 өмгөөлөгчийг прокурорынхон баривчилжээ.

### Оросын Батлан хамгаалах яамны ажилтан асан

#### авлигын хэргээр хоригдов

**ОХУ.** Оросын Батлан хамгаалах яамны ажилтан асан Евгений Васильевад томоохон авлигын хэргийн улмаас 5 жил шоронд хорих ял ногдуулсан байна. Оросын Хууль зүйн мэдээллийн агентлагийн мэдээлж байгаагаар Евгений Васильева албан тушаалаа урвуулан ашигласан, мөнгө угаасан, луйвар хийсэн зэрэг 8 хэрэгт буруутай болохыг тогтоосон аж.

Хатагтай Евгений Васильева нь Батлан хамгаалахын сайд асан Анатолий Сердюковын шадар туслахаар ажиллаж байсан юм. Мөн түүний хамт төрийн өмчит “Оборонасервис” холдингд ажиллаж байсан 4 этгээдэд ял ногдуулжээ. Тэднийг хууль бусаар “Оборонасервис” холдингийн бүтээгдэхүүнийг хямд зарж байсныг тогтоосон бөгөөд хэргийн улмаас ОХУ-д 3 тэрбум рубль (60 сая ам.доллар)-тэй тэнцэх хэмжээний хохирол учирсан байна. 36 настай Евгений Васильева уг хэрэгт буруугүй болохоо мэдэгдэж, уг ялыг эдлэх хугацааг нь түр хойшлуулахыг улсын прокуроруудаас хүсээд байгаа юм.

**Эх сурвалж: Гадаадын мэдээллийн агентлагууд**

## ХЯНАЛТ ШАЛГАЛТ

### Төрсөн охиныхоо компанитай гэрээ байгуулжээ

Авлигатай тэмцэх газрын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас 1800-1969 утсаар ирүүлсэн албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийн мөрөөр хяналт шалгалт хийж, тодорхой зөрчлийг илрүүлэн ажиллаж байна.

Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Ү.Батчулуун нь тус аймгийн Засаг даргын Тамгын газраас зарласан Аргалант сумын цэцэрлэгийн цэвэр усны нэгдсэн шугам сүлжээний шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт сонгон шалгарсан өөрийн төрсөн охины 100 хувийн эзэмшлийн “Өрнөх цамхаг” ХХК-тай гэрээ байгуулж, санхүүжилтийн эрх нээсэн тухай мэдэгдэл дээр нэгдүгээр гарын үсэг зурж баталгаажуулсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн байна. Иймд Авлигатай тэмцэх газраас Ү.Батчулуунд хариуцлага тооцуулахаар Төв аймгийн Засаг даргад хандав.

### Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмыг боловсронгуй болгох шаардлагатай

Авлигатай тэмцэх газар иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийн мөрөөр албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авч хянан шалгаж байна. Хяналт шалгалтаар Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагаа, тэдгээрийн зарцуулалтын талаар нэлээд зөрчил илэрч байна.

Тухайлбал, Хөвсгөл аймгийн Рашаант сумын Сум хөгжүүлэх сангийн зөвлөлийн гишүүд нь 2013 онд тус сумын 90 жилийн ойн арга хэмжээнд зориулж тус сангаас сумын Засаг даргын орлогч Д.Өнөрболдын нэр дээр 10 сая төгрөгийн зээлийг зориулалтын бусаар гаргуулж зарцуулсан, мөн Завхан аймгийн Цэцэн-Уул сумын Засаг дарга Б.Оргилсайхан нь төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийг ахлан ажиллах явцдаа бусдын гуйлтаар журамд заасан шаардлага хангаагүй болон

өөр сумын иргэний хүсэлтийг үндэслэн зээл олгосон байна. Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Санхүү, хөдөлмөр нийгмийн хамгааллын хяналтын хэлтсийн дарга Б.Дарихжав нь “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих” сан болон “Сум хөгжүүлэх сан”-гаас өөрийн нэр дээр зээл авч, авсан зээлээ зориулалтын бусаар ашиглаж зарцуулсан байх тул уг зөрчилд Авлигын эсрэг хуулийн 13 дугаар сарын 13.8.3 дахь хэсэгт заасныг үндэслэн хариуцлага тооцуулахаар Сэлэнгэ аймгийн Засаг даргад албан бичиг хүргүүлэв.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байх бөгөөд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа журмын зохицуулалтаар зөрчил гаргасан албан тушаалтанд ямар хуулийн дагуу эрхэн хариуцлага тооцуулж ажиллах нь тодорхойгүй байгаа нь авлига, ашиг сонирхлын зөрчил гарч болох нөхцөлийг бий болгож байх тул дээрх журмыг боловсронгуй болгох, зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа болон төсөл үр дүнтэй хэрэгжиж буй эсэхэд хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаарх албан бичгийг Авлигатай тэмцэх газраас Аж үйлдвэрийн яаманд хүргүүлээ.

### Монголбанкны удирдах албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах

Авлигатай тэмцэх газраас Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийг тус тус үндэслэн төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд Монголбанкны удирдах албан тушаалтнуудын 2011-2014 онуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгалаа.

Мэдүүлгийн хяналт шалгалтаар албан тушаалтнуудын дийлэнх нь хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргах заавар, зөвлөмжтэй сайн танилцаагүй, мэдүүлгийг гаргахдаа нягталж шалгадаггүй, хайнга ханддаг, гэр бүлийн гишүүдийн дундын өмчлөлд бүртгэлтэй эд хөрөнгийг мэдүүлдэггүй, хөрөнгө борлуулсны орлого мэдүүлдэггүй, бусдад худалдсан тээврийн

хэрэгслийг худалдан авсан иргэний нэр дээр шилжүүлээгүй, цалингийн орлогыг гарт олгосон дүнгээр мэдүүлэх, худалдан борлуулсан хөрөнгийн орлого, эзэмших эрх бүхий газар, гэр бүлийн гишүүдийн хөрөнгө оруулсан компани, хувьцааг мэдүүлээгүй, харилцах данс, картын данс, бэлэн мөнгөний үлдэгдлийг оны эцсийн үлдэгдлээр бус, мэдүүлэг гаргах үеийн байдлаар мэдүүлсэн зэрэг нийтлэг зөрчил гаргасан байна.

Хяналт шалгалтын хүрээнд Монгол-банкны газар, хэлтсийн захирал 10 албан тушаалтанд илэрсэн зөрчлийн шинж байдлыг харгалзан үзэж өөрсдөд нь анхааруулах, 7 албан тушаалтанд хөрөнгө, орлогоо худал мэдүүлсэн үндэслэлээр хариуцлага тооцуулахаар Монголбанкны захиралд албан бичгийг хүргүүлээ. Авлигатай тэмцэх газраас дээрх нийтлэг зөрчлүүдийг арилгах, аливаа алдаа, зөрчлийг дахин гаргуулахгүй байхад чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

### Иргэдээс 20 мянган төгрөгийн хураамж авах шийдвэрийг хүчингүй болгуулав

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг Барилгын хөгжлийн төв төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын чиг үүргийг судлан үзэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээний ил тод, нээлттэй байдалтай танилцах зорилгоор тус төвд ажилласан юм. Тус төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн хүрээнд тусгай зөвшөөрөл олгох асуудлаар баримт бичгийг хүлээн авах, хяналт хийх чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйлчилгээ үзүүлэхдээ иргэдээс 20 мянган төгрөгийн хураамж авч буйг үндэслэлгүй гэж үзэж, уг төлбөр хураамжийг авахтай холбогдох шийдвэрийг хүчингүй болгуулахаар Авлигатай тэмцэх газраас албан бичиг хүргүүлсэн.

Уг албан бичгийн хүрээнд иргэдээс дээрх хураамжийг авахад мөрдөж байсан “Архивын сан хөмрөгөөс баримт ашиглах, лавлагаа мэдээлэл олгох, хүлээн авах журам, Барилгын архиваас лавлагаа олгох үнэ тариф”-ыг Барилгын хөгжлийн төвийн захирлын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн А/128 дугаар тушаалаар хүчингүй болгож, энэ өдрөөс эхлэн Архивын ерөнхий газрын даргын 2007 оны 03 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн архивын баримт ашиглалтын нийтлэг журам”, “Төрийн архиваас үзүүлэх төлбөрт үйлчилгээний үнийн тариф”-ыг мөрдөж ажиллахаар болсон байна.

## ХЭН ЮУ ХЭЛЭВ?

### УИХ-ын гишүүн Ц.Нямдорж:

Хэрэг хийчихээд АТГ руу улстөрчид өөрсдөө давшилдаг зүйл хэзээ ч байж болохгүй. Өөрсдөө хэрэг л хийхгүй байх хэрэгтэй шүү дээ.

### УИХ-ын гишүүн М.Зоригт:

Хуулийн дээгүүр заларч суудаг дээдсийн оймсыг нь хүртэл гозолзуулж чадаж байгаа АТГ-ыг авч үлдэх л хэрэгтэй.

### Монгол Улсын Ерөнхийлөгч

#### Ц.Элбэгдорж:

Монгол Улс дөрөвхөн жилийн дотор Транспаренси Интернэйшнл байгууллагын авлигын үзүүлэлтээр 120-оос 80 дугаар байр руу ахиж чадсанд би бахархаж байна. Бидэнд одоо ч гэсэн хийх ажил их байна.

### АТГ-ын дарга, тэргүүн комиссар

#### Н.Ганболд:

Өнөөдрийн хэмжээнд 468 хүн ШШГЕГ-ын 461 дүгээр ангид хоригдож байгаа. Манай байгууллагын саналаар тэнд дөрвөн хүн байгаа. 3 эрүүгийн хэрэгт 4 хүн цагдан хоригдох арга хэмжээ авагдсан.

### УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар:

АН-ынхан сонгуулиар авлигатай тэмцэнэ гээд байсан үнэндээ АТГ-тай тэмцэх гээд байсан юм байна шүү дээ. Үг үйлдлийн, ам ажлын зөрөө гэж...

### Налайх дүүргийн 5 дугаар хорооны иргэн Ч.Лхагвасүрэн:

АТГ-ын үйл ажиллагаа идэвхтэй сайн байгааг иргэн би мэдэрч байна.

### Сэтгүүлч Ц.Оюундарь:

Авлига гэдэг зүйл эрх мэдэлтнүүдэд л байдаг. Тиймээс эрх мэдэлтнүүдийг хүний, өөрийн гэлгүй шалгаж байж авлигатай тэмцэх ажиллагаа эхэлнэ. Авлигатай тэмцэх газар бол бүрэн эрхийнхээ хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа.

## АСУУВАЛ ХАРИУЛЪЯ

### АТГ улс төрийн хүсэл зоригоос илүү Монголын ард түмний хүсэл эрмэлзэл дээр үндэслэж байгуулагдсан

Авлигатай тэмцэх газрыг татан буулгах тухай яригдаж байна. Авлига маш их хавтгайрсан гэж иргэн би ойлгодог. Ийм цаг үед Авлигатай тэмцэх газаргүйгээр авлигатай тэмцэх боломж байна уу?

Авлигатай тэмцэх газар 2007 онд байгуулагдахаас өмнө авлигатай хэн тэмцэж байсан бэ? Тэмцдэг систем тэр үед байсан. 10 мянган цагдаа, 400 гаруй прокурор, 300 шүүгч, дээрээс нь тагнуулын байгууллага авлигатай тэмцэж л байсан. Авлига гэдэг зүйл тэр үед байгаагүй биш, байсан. Гэхдээ энэ биш юм байна, энэ шүүх ялзарчихлаа, энэ прокурор худалдагдчихлаа, энэ цагдаа чадахгүй юм байна гэж тэр үед үзсэн учраас Авлигатай тэмцэх газрыг байгуулсан. Гэхдээ энэ байгууллага 100 гаруй албан хаагчтай. Та нар бод доо. Бүх цагдаа, прокурор, шүүгч нийлээд хэчнээн тоо гарах вэ? Тэд аймаг орон нутагт салбар нэгжтэй. Тэд тэмцээд дийлээгүй байхад орон нутагт салбаргүй Авлигатай тэмцэх газар дангаараа, ганцаараа авлигыг 100 хувь төгс шийднэ гэдэг худлаа. Гэхдээ бид авлигатай тэмцэнэ, тэмцэж байгаа, хүрээг нь бууруулна, бууруулахын төлөө ажиллаж байгаа, олон нийтийн хүлээлтэд эерэг хариу өгөхөөр ажиллаж байгаа. Энэ байгууллага улс төрийн хүсэл зоригоос илүү Монголын ард түмний хүсэл эрмэлзэл дээр үндэслэж байгуулагдсан. Тийм учраас бид олон нийтийн итгэлийг алдахгүйн тулд сайн ажиллах ёстой гэдгээ үргэлж ухамсарладаг.

*Нийслэлийн Налайх дүүргийн 5 дугаар хорооны иргэдтэй хийсэн уулзалтын тэмдэглэлээс*

### Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг прокурорын саналд үндэслэн шүүгчийн захирамжаар шийдвэрлэдэг

Авлигатай тэмцэх газар өөрийн дураар барьдаг, хорьдог гэсэн мэдээллийг сүүлийн үед гаргах боллоо. УИХ-ын гишүүд хүртэл энэ талаар ярьж, хэлж байна. Авлигатай тэмцэх газар хүнийг дураараа барьж, хорьдог юм уу?

*Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны иргэн А.Цогбадрах*

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг явуулахдаа нэн тэргүүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авахаас аль болох зайлсхийдэг бөгөөд манай эрүүгийн хэргийн судалгаагаар 2013 онд нийт 48, 2014 онд 29 хүнийг сэжигтэн, яллагдагчаар цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авчээ. Энэ нь 2014 онд өмнөх оныхоос 39.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай мөрдөн байцаагчийн саналыг прокурор танилцан, хянаж үзсэний дараагаар таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд өөрийн саналаа шүүхэд танилцуулах бөгөөд шүүгч өмгөөлөгч, прокурорыг байлцуулан тухайн сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих үндэслэлтэй эсэх асуудлыг хянан шийдвэрлэж захирамж гаргадаг. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан шүүгчийн захирамжийн хэрэгжилтэд прокурор байнгын хяналт тавьдаг болно. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг үргэлжлүүлэн сунгах эсэх асуудлыг мөн шүүгч хянан үзэж, шийдвэрлэдэг юм.